



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 7 дугаар тэмдэглэлд:

ХИИ.ХЭЛЭЛЦСЭН нь:


Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын конторын барилга (хуучин)-ыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албанд балансаас балансад шилжүүлэх тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2019 оны 1-4/770 дугаар албан бичгээр өөрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын конторын барилга (хуучин)-ыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн харьяа Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албанд балансаас балансад шилжүүлэх саналтай байгаа тул шийдвэрлэж өгөхийг хүссэн байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 96,402,491.00 (ерэн зургаан сая дөрвөн зуун хоёр мянга дөрвөн зуун ерэн нэг) төгрөгийн балансын үнэ, 573,824.36 (таван зуун далан гурван мянга найман зуун хорин дөрвөн төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2004 онд ашиглалтад орсон Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13-р баг, Т.Намнансүрэнгийн гудамжинд байрлах конторын барилга (хуучин)-ыг Өвөрхангай аймгийн Шүүхийн шинжилгээний албанд балансаас балансад шилжүүлэх саналыг дэмжиж, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн шийдвэрлүүлэхээр тогтов.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР